

ОЮУТНЫ БАЙРНЫ ДОТООД ЖУРАМ

Нэг.ОЮУТНЫ БАЙРАНД БАРИМТЛАХ ДЭГ

- § ХИС-ийн дотуур байр нь оюутан хүнхэвийн амьдрах нөхцөлөөр хангагдахуйц тоноглогдсон байна;
- § Оюутны байранд оюутан байрлуулах асуудлыг салбар сургуулиасолгосонзөвшөөрлийнхуудсыгүндэслэнбайрны зохицуулагч гүйцэтгэнэ;
- § Оюутанхүлээнавахдааэцэг, эхболонбайрнызохицуулагчхоёрынхамтарсангэрээбайгуулна;
- § Оюутны байрны нийтийн эзэмшлийн хонгил, шат, халуун ус, 00-оос бусад талбайг байранд суугч оюутан цэвэрлэнэ;
- § Байрыг цэвэр үзэмжтэй шаардагдах тоног төхөөрөмжөөр хангаж хичээлийн жилийн эхэнд эзэмшигчдэдкартаар хүлээлгэн өгч, гарсан тохиолдолд хүлээн авч байна;
- § Байранд суугч оюутан бүр өрөө тасалгаагаа цэвэр нямбай эзэмшиж байрны үйлчилгээний газруудаарзөвболовсонүйлчлүүлж тогтоосон цагийн хуваарийг нарийн баримтлана;
- § Байрнаасбуюуоюутнызөвлөлөөсзохиогдожбуйолоннийтийнажилдтогтмолоролцожб айна;
- § Эцэг, эхийгзохицуулагчийнзөвшөөрөлтэйгөөр 3 хоног, төрсөнахдүүг 1 хоногбайрлуулна;
- § Байрны дотоод журамтай танилцан түүнийг бүрэн биелүүлэхээ зөвшөөрсөн байна;

Хоёр. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- § Оюутны байрны цагийн хуваарийг зөрчих;
- § Хуваарилж өгсөн өрөө тасалгаа, тавьсан эд хогшлыг дур мэдэн солих, өрөө тасалгааны болон нийтийн эзэмшлийн эд хогшил, тоноглол, цоожийгэвдэх, хэмхлэх;
- § Байранд цэвэрч бус суух, гадны хүмүүсийг зөвшөөрөлгүй оруулах;
- § Согтууруулах ундаа оруулах, хэрэглэх, байраар сэлгүүцэх, ноцолдох, хөгжим чанга дуугаар сонсох зэргээр бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах;
- § Өрөөний хананд хадаас хадах, цонх салхивчийг онгойлгон эзгүй орхих, тагтаар хог хаях;

- § Тагтаар хүн оруулах, гаргах, угаалтуур, суултуур дотор элдэв хог хаягдал хийхгүй байх;
- § Хөлдөөгчинд хийх махны хэмжээг хэтрүүлэх;
- § Охид, хөвгүүдийг нэг өрөөнд хамт оруулах;
- § Муур, нохой болон бусад амьтан тэжээх;
- § Оюутны байранд ямар нэгэн үйлчилгээ явуулах;
- § Хүнсний мухлагт архи, тамхи, хугацаа хэтэрсэн бараа бүтээгдэхүүн зарахыг хориглох;
- § Цахилгааны гэмтэлтэй болон, хэт өндөр цахилгаан хэрэглэдэг тогоо болон плитка ашиглахыг хориглоно;

Гурав.ЗӨРЧИЛ ГАРГАСАН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- Байранд суугчид нь зохицуулагчийн тавьсан шаардлагыг биелүүлнэ. Эс биелүүлбэл хариуцлагын талоныг цоолох ба гурван удаа цоолуулсан тохиолдолд оюутны байрыг суллаж өгнө;
- Цонх, тагтаар хүн оруулах, гаргах, байранд архи уух, танхайрах зэрэг ноцтой зөрчил гаргавал байрнаас албадан гаргаж төлбөрийг буцааж олгохгүй;